



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 9/619

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын утаа, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Ц.Гансүх (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Х.Тайванбаяр (Мөрөн сумын Засаг дарга)

3.Нямбаяр (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Н.Шинэбаяр (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын Газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Нямбат (Аймгийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Сүхээ ("Хөвсгөл Ус суваг" ХХК-ийн ерөнхий инженер)

Б.Баттөмөр ("Хөвсгөл Дулааны станц" ТӨХК-ийн бүрэн эрхт төлөөлөгч)

Г.Даваадорж ("Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн ерөнхий инженер)

Г.Энхбаяр (Мөрөн сумын иргэн /тохиролцсоноор/)

Нарийн бичгийн дарга: Э.Аззаяа (Аймгийн ерөнхий архитектор)

2. Мөрөн сумын утаа, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох техник эдийн засгийн үндэслэл, судалгаанд үндэслэн боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гандэлгэр)-д даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011858